



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.28 № 445

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр  
хуульд заасан шаардлагад  
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Гүндсамбуугийн Батцэнгэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Audit(D)Дүгнэлт/2024

013000634

## Дүгнэлт

Гүндсамбуугийн Батцэнгэлийн /РД:ИН72052611/ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Г.Батцэнгэлийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Завхан аймгийн Тэлмэн сумын сонгуулийн хороо, бие даан нэр дэвшигч Г.Батцэнгэл нарт.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

**Завхан аймаг болон Тэлмэн сумын 2024 оны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Гүндсамбуугийн Батцэнгэлийн мөрийн хөтөлбөр.**

### НЭГ.

1.Хууль зөрчсөн тендер шалгаруулалтыг таслан зогсоож, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахтай холбоотой аливаа асуудалд хатуу хариуцлага тооцдог орчныг дэмжиж ажиллана.

### ХОЁР.

2.Иргэдийг аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, сургалт үйл ажиллагааг зохион байгуулна.

### ГУРАВ.

3.Төрийн албанд мэргэшсэн, мэдлэг чадварын шалгуур хангасан боловсон хүчнээр хангах, хууль бусаар ажлаас халах явдлыг таслан зогсоох талаар өөрийн байр сууриа илэрхийлж ажиллана.

### ДӨРӨВ.

4.Орон нутгаас төрж гарсан шилдэг боловсон хүчний мэргэжил, мэдлэг, ур чадварыг өөрийн орон нутгийн хөгжилд татан оролцуулж хамтран ажиллана.

### ТАВ.

5. Эмч эмнэлгийн ажилтны ур чадварыг дээшлүүлэх үр дүнтэй хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

### ЗУРГАА.

6. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулахад хамтран ажиллана.

## **ДОЛОО.**

7. Сургууль цэцэрлэгийн багшийн хөгжлийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, зорилтод нийцүүлэн Эко сургууль цэцэрлэгийг дэмжиж ажиллана.

## **НАЙМ.**

8. Алслагдсан нутгийн малчдын хүүхдийг Сургуулийн өмнөх боловсролд хамруулах ажлыг дэмжиж, судалгаа тандалтад хамтран ажиллана.

## **ЕС.**

9. Төрийн албан хаагчдад тус аймгаас Улаанбаатар хотод сурч, ажиллаж байгаа мэргэжилтэн залуусын дэмжлэгтэй Монгол бичиг, Англи хэл сургах үйл ажиллагааг зохион байгуулж хамтран ажиллана.

## **АРАВ.**

10. Шинээр уул уурхайн хайгуул, ашиглалтын лиценз олгохгүй байх, байгаль орчноо хамгаалахад онцгой анхаарч ажиллана.

## **АРВАН НЭГ.**

11. Гол мөрнийг бохирдуулах, ойн сан ашиглалт байгаль орчинд хохирол учруулах хууль бус үйл ажиллагааг таслан зогсооно.

## **АРВАН ХОЁР.**

12. "Тэрбум мод"- Үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилтийг бууруулах мод бут сөөг тариалах ажлыг эрчимжүүлэн үе шаттайгаар зохион байгуулна.

## **АРВАН ГУРАВ.**

13. Аялал жуулчлалыг дэмжиж ажиллана.

## **АРВАН ДӨРӨВ.**

14. Тэлмэн суманд өндөр ашиг шимтэй мал аж ахуйг хөгжүүлэхэд төсөл бичиж хэрэгжүүлнэ.

**АРВАН ТАВ.**

15. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг дэмжиж, орон нутагт малын гаралтай түүхий эд боловсруулах бага оврын тоног төхөөрөмжийн цех ажиллуулан анхан шатны боловсруулалт хийж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

**АРВАН ЗУРГАА.**

16. Хүнсний ногоо болон малын тэжээлийн тариалалтыг дэмжиж ажиллана.

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН:

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ



(Г. БАТЦЭНГЭЛ)

2024 оны 07 сарын 18 -ны өдөр

